

## ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН МЭДЭЭ (2022 оны 3 дугаар улирлын байдлаар)

2022 оны 09 дугаар сарын 21

Улаанбаатар хот

Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу ажиллаж байна.

### Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас нийт 196 өргөдөл ирснийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем /<https://egr.ulaanbaatar.mn> /-д бүртгэн, 186 өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан бол 10 өргөдөл шийдвэрлэх шатандаа явагдаж байна. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй болно. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 14 цаг 57 минут байна.

### Хоёр. Өргөдөл, гомдлын хандалтын мэдээ (өссөн дүнгээр)

2022 оны I- III улирлын байдлаар байгууллагад ирсэн өргөдлийн хандалтыг төрлөөр нь ангилбал:

- Иргэнээс гаргасан санал, хүсэлт-2
- Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл-5
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл– 17
- Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл– 18
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл–24
- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл- 54
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл- 66

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:




График 1. Өргөдлийг төрлөөр нь ангилсан байдал.

**Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үеүүдтэй харьцуулсан байдал**

Хүснэгт1

Д/д	Хугацаа	2021.03 улирал	2022.03 улирал
<b>Ерөнхий үзүүлэлт</b>			
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	4 хоног 15 цаг 59 минут	9 хоног 14 цаг 57 минут
2	Хандалтын тоо	36	65
3	Зөрчлийн үзүүлэлт	0	0
<b>Өргөдөл гомдлын хандалтын төрөл</b>			
4	Иргэнээс гаргасан санал, хүсэлт	0	2
5	Ажилд шилжин, дэвшин ажиллах тухай өргөдөл	0	2
6	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл	10	6
7	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө хүссэн өргөдөл	5	6
8	Захиргааны чөлөө хүссэн өргөдөл	8	8
9	Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл	10	29
10	Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл	3	12




График 2. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээг өмнөх улиралтай харьцуулсан байдал


### Дүгнэлт:

Графикаас харахад газрын хэмжээнд 2022 оны III улиралд ирсэн өргөдлийн тоо өмнөх мөн үетэй харьцуулбал 1,8%-иар, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоногоор тус тус өссөн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног 14 цаг 57 минут байгаа нь 2021 оны дундаж хугацаанаас өссөн нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2-т заасан хугацааг баримтлан шийдвэрлэж байгаа болон байгууллагын дотоод журамд заасан ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хүссэн өргөдлийн дагуу тухайн ажлын байрны ачаалалд мониторинг хийсний дараа уг хүсэлтийг шийдвэрлэж буйтай холбоотой юм. Мөн агентлаг хариуцсан нярав, нягтлан нь хөрөнгө санхүүтэй холбоотой ажил, албан тушаалтай тул ажил хүлээлцэх явц удаашралтай байна.

Ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан технологийн шийдэл ашиглан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг 10 хоног тутамд хөтлөн, 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд манай байгууллагад хамааралгүй 4 өргөдөл гомдлыг холбогдох байгууллагад өдөрт нь шилжүүлэн ажиллалаа.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:  
ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН  
АЖИЛТАН



Б.ХЭНМЭДЭХ

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:  
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ХАРИУЦСАН  
АЖИЛТАН



А.НОМИНЗУЛ